

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИРГЭДИЙН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2024 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2024 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1108 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс судлагдаж байгаа 95, хуулийн хугацаанд 1012, хугацаа хэтрүүлэн 1 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 05 хоног 18 цаг 03 минут байна.

Үүнээс Засаг даргын Тамгын газарт 197 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж байгаа 19, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 178, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 07 хоног 19 цаг 23 минут байна.

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэ н		Судлагдаж байгаа		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэ н		Шийдвэрлэлтий н дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	202 3 III/2 5	202 4 III/2 5	2023 III/25	2024 III/25	202 3 III/2 5	202 4 III/2 5	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	202 3 III/2 5	202 4 III/2 5
ИТХ												
Засаг даргын Тамгын газар	163	197	137	178	26	19			06х 23ц 11м	07х 19ц 23м	2	
Харьяа хэлтэс, алба, тасаг	898	618	833	552	60	65	5	1	08х 06ц 55м	06х 13ц 37м	142	39
Дүүргийн өмчит үйлдвэрий н газрууд	17	14	17	12		2			05х 07ц 06м	09х 03ц 45м	5	11
Хороод	112	125	104	122	8	3			05х 23ц 17м	02х 14ц 12м	61	16
Эмнэлэг	144	152	141	146	3	6			02х 20ц 19м	02х 13ц 40м	12	23
Цэцэрлэг, сургууль	23	2	23	2					02х 19ц 10м	02х 00ц 21м	11	
НИЙТ	135 7	110 8	1255	1012	97	95	5	1	07х 05ц 07м	05х 18ц 03м	233	89